



**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар A/17

Эрдэнэт

Г Цахим төлбөрт тооцооны систем  
нэвтрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолын хавсралт “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн 5 дугаар зүйлийн 5.3.10 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд цахим төлбөрт тооцооны систем нэвтрүүлэх зорилгоор төлбөрт үйлчилгээг өөрийн гар утаснаасаа интернэт банкаар төлбөрөө төлөх боломжийг иргэдэд олгож QR /КЮ-AP/ код буюу QPay үншуулах үйлчилгээг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлсүгэй.
2. Төлбөрт үйлчилгээгээр үйлчлүүлэгчдэд “Цахим төлбөрийн баримтын систем” /ebarimt/-ийг цахим болон цаасан хэлбэрээр иргэдэд чирэгдэл учруулахгүйгээр тухай бүр олгож ажиллахыг нягтлан бодогч (Ж.Нямжаргал)-д үүрэг болгосугай.
3. Байгууллагын төлбөрт үйлчилгээг цахим үйлчилгээнд шилжүүлсэнтэй холбогдуулан заалаар үйлчлүүлэгчдэд бэлэн мөнгөний үйлчилгээ үзүүлэхгүй байх, “QPay үйлчилгээ”-ний талаарх зөвлөмж, зааварчилгааны зурагт хуудас байршуулах, цахимаар сурталчлах ажлыг зохион байгуулж, ажлын тайланг сар бүр тайлagnаж ажиллахыг нягтлан бодогч (Ж.Нямжаргал), нярав-касс (Э.Баасанням) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  д.дэлгэрбаяр